



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 11 сарын 15 өдөр

Дугаар А/692

Арвайхээр

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5.а, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 02/01 дүгээр тогтоолоор батлагдсан аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны “БҮТЭЭЛЧ ӨВӨРХАНГАЙ – 2020” хөтөлбөрийн 3.3.5.1 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хүүхдэд ээлтэй орон нутаг хөтөлбөрийн хүрээнд хүүхдэд ээлтэй орчин, хүүхдэд ээлтэй бодлого, шийдвэр гаргахад тэдний оролцоог хангасан байдал, хүүхдэд эрүүл аюулгүй, аз жаргалтай амьдрах нөхцөл бүрдүүлсэн эсэхэд үнэлгээ хийх үнэлгээний ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2. Хөтөлбөрт үнэлгээ хийх ажлыг 2019 оны 11 дүгээр сарын 20-ны дотор зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга, ажлын хэсгийн ахлагч (Б.Сайнжаргал)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА




Г.ГАНБОЛД

011101313

D:My Doc. Zahiramj. Zasag darga

Аймгийн Засаг даргын 2019 оны 11...
дугаар сарын 15...ны өдрийн 11.92 дугаар
захирамжийн хавсралт



АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

- Ажлын хэсгийн ахлагч: Б.Сайнжаргал -Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Нийгмийн бодлогын хэлтсийн дарга
- Нарийн бичгийн дарга: Ж.Энх-Амар -Аймгийн Засаг даргын дэргэдэх Гэр бүл,
хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга
- Гишүүд: Ц.Энхцэцэг -Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын
хэлтсийн мэргэжилтэн
- Я.Жаргал -Аймгийн Засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн газрын
Хяналт-шинжилгээ, мэдээллийн хэлтсийн дарга
- С.Дагиймаа -Аймгийн Засаг даргын дэргэдэх Мэргэжлийн хяналтын
газрын улсын байцаагч
- Н.Цэвээндулам -Аймгийн Засаг даргын дэргэдэх Гэр бүл, хүүхэд,
залуучуудын хөгжлийн газрын ахлах мэргэжилтэн
- Г.Уранбат -Аймгийн Цагдаагийн газрын Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн
гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ахлах мэргэжилтэн,
цагдаагийн хошууч
- Г.Мөнх-Эрдэнэ -Аймгийн Засаг даргын дэргэдэх Боловсрол, соёл, урлагийн
газрын мэргэжилтэн
- Т.Дэлгэрмаа -Арвайхээр сумын Засаг даргын Тамгын газрын Гэр бүл,
хүүхэд, залуучуудын асуудал хариуцсан мэргэжилтэн